

**МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ, АМЬТАН УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД,
БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ҮЕИЙН ХОРИО ЦЭЭРИЙН
ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 06 дугаар
сарын 28-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч мал аж ахуйн салбарын хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, мал эмнэлгийн хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалт, гаалийн болон мэргэжлийн байгууллагын дундын мэдээллийн цахим санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, мэдээлэл дамжуулах, хэрэглэхтэй холбоотой зохицуулалт, мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхтэй холбоотой төрийн байгууллагуудын бүрэн эрхийг тодорхой болгохоор уг хуулийн төслүүдийг боловсруулсан байна.

Мал аж ахуйн салбарын хуулиудын давхардал, хийдэл зөрчлийг арилгаснаар Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон бусад бодлогын баримт бичигт тусгагдсан хүнсний аюулгүй байдлыг хангах, мал, амьтны эрүүл мэнд, малын удмын санг хамгаалах, баталгаажуулах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох таатай орчин бүрдэнэ гэж үзэн хууль санаачлагчид хуулийн төслийг боловсруулан, d.parliament.mn цахим сайтад байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин Гаалийн ерөнхий газрын хилийн мэргэжлийн хяналтын алба мах экспортлох зөвшөөрлийг өгч байгаа нь олон улсын дүрэм, журмыг зөрчиж байгаа гэснийг тодруулах, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал хамгаалалттай аж ахуйн талаар, түүнчлэн малын гоц халдварт өвчний онош нь батлагдаагүй байхад нийтэд мэдээлэх, баталгаажсан тохиолдолд олон улсын байгууллагад хүргүүлэхгүй нуун дарагдуулахыг хориглоно гэж заасныг тодруулах, Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан,

орон нутгийн мал эмнэлгийн албаны хүний нөөцийн дутагдлыг хэрхэн шийдвэрлэх, малын гоц халдварт өвчнийг бууруулахад салбарын яам бодлогын шинэчлэл хийж байгаа эсэх, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх асуудалд баримталж байгаа бодлогын талаар, Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир мал, махыг экспортлох нэг цонхны бодлогын явц байдлын талаар асуулт асууж, хариулт авлаа.

Түүнчлэн хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир мал, махны экспортыг хүндрэл, чирэгдэл учруулахгүйгээр шийдвэрлэх, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг төрөөс тууштай дэмжих, Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин мал эмнэлгийн салбарын боловсон хүчнийг бэлтгэх, малын эрүүл мэндийг хамгаалах, дархлаажуулалт болон мал эмнэлгийн үйлчилгээний хөлсийг тухайн жилийн инфляцтай уялдуулан тогтоох зохицуулалтыг холбогдох хуулийн төсөлд тусгахад салбарын яам анхаарч ажиллах, Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал хөдөө аж ахуйг шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлэхэд анхаарч, шинжлэх ухааны хүрээлэн, салбар яамдын уялдаа холбоог хангаж, хамтарч ажиллах, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ хөдөө аж ахуйг шинэчлэх, нүүдлийн мал аж ахуйгаас хагас суурин хэлбэрт шилжих, бэлчээрийн асуудлыг зохицуулах, эрүүл бүсийг байгуулах, ингэснээр мал, махыг экспортлох асуудлыг нэмэгдүүлэх талаар нэгдсэн бодлого, төлөвлөгөө гаргаж ажиллах нь зүйтэй гэсэн санал хэллээ.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 71.4 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ

Ж.БАТ-ЭРДЭНЭ



ТУС3764 9023951393 9087184